



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 265

Улаанбаатар хот

Шалгуур үзүүлэлтийг шинэчлэн  
батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2015 онд зохион байгуулах спортын төрлийг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийг хавсралтаар баталсугай.
2. Тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 93 дугаар тушаалаар баталсан хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Эрдэнэчимэг/, Нийтийн Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Х.Бакытжан/ -т тус тус даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

030903

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 07 сарын 08 өдрийн  
265 дугаар тушаалын хавсралт

### СПОРТЫН ТӨРӨЛ ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**Нэг.** Спортын холбоо нь улсын аварга шалгаруулах тэмцээнүүдийг хэрхэн зохион байгуулсан байдлаар дараах аргачлалын дагуу өгсөн үнэлгээний нийлбэрээр дүгнэнэ.

д/д	Шалгуур үзүүлэлт	Тооцох аргачлал	Үнэлгээ	Нийлбэр
1.	Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн	Зохион байгуулсан бол	20 оноо	40 оноо
		Зохион байгуулаагүй бол	0 оноо	
2.	Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн	Зохион байгуулсан бол	10 оноо	
		Зохион байгуулаагүй бол	0 оноо	
3.	Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн	Зохион байгуулсан бол	10 оноо	
		Зохион байгуулаагүй бол	0 оноо	

**Хоёр.** Спортын холбооноос тамирчдаа Олимпийн наадам, Азийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээн, тивийн аварга шалгаруулах тэмцээнд хэрхэн оролцуулсан байдал болон үзүүлсэн амжилтыг нь дараах аргачлалын дагуу өгсөн үнэлгээний нийлбэрийн дунджаар дүгнэнэ.

д/д	Шалгуур үзүүлэлт	Тооцох аргачлал	Үнэлгээ	Нийлбэр
1.	Олимпийн наадам	Медаль авсан бол	30 оноо	40 оноо
		Эрх авсан бол	10 оноо	
		Эрх аваагүй бол	0 оноо	
2.	Азийн наадмууд	Медаль авсан бол	30 оноо	
		Оролцсон бол	10 оноо	
		Оролцоогүй бол	0 оноо	
3.	Дэлхийн зэрэглэлийн тэмцээн	Медаль авсан бол	30 оноо	
		Оролцсон бол	10 оноо	
		Оролцоогүй бол	0 оноо	
4.	Тивийн аварга	Медаль авсан бол	30 оноо	
		Оролцсон бол	10 оноо	
		Оролцоогүй бол	0 оноо	

**Гурав.** Спортын холбооны санхүүгийн үйл ажиллагааг дараах аргачлалын дагуу өгсөн үнэлгээний нийлбэрийн дунджаар дүгнэнэ.

д/д	Шалгуур үзүүлэлт	Тооцох аргачлал	Үнэлгээ
1.	Тухайн жилд төрөөс гэрээгээр авсан зардлын баримтын бүрдэлт, гэрээний дүгнэлт	Гэрээг хугацаандаа дүгнүүлсэн бол	10 оноо
		Гэрээг хугацаандаа дүгнүүлээгүй,	0 оноо
2.	Санхүү хариуцсан орон тооны болон гэрээт нягтлантай эсэх (гэрээ байх)	Санхүү хариуцсан орон тооны болон гэрээт нягтлантай бол	10 оноо
		Санхүү хариуцсан орон тооны болон гэрээт нягтлангүйд бол	0 оноо
3.	Санхүүгийн тайлан	Тухайн жилийн санхүүгийн тайланг тухайн харьяах төрийн сангийн хэлтэс,	10 оноо

		татварын албанд гаргаж өгсөн бол	
		Тухайн жилийн санхүүгийн тайланг тухайн харьяах төрийн сангийн хэлтэс, татварын албанд гаргаж өгөөгүй	0 оноо
4.	Аудитийн тайлан	Тухайн жилийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн бол	10 оноо
		Тухайн жилийн санхүүгийн тайланд аудит хийлгээгүй бол	0 оноо

**Дөрөв.** Спортын холбооноос хөгжлийн бодлогын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааг дараах аргачлалын дагуу өгсөн үнэлгээний нийлбэрийн дунджаар дүгнэнэ.

д/д	Шалгуур үзүүлэлт	Тооцох аргачлал	Үнэлгээ
1.	Хуралд оролцсон	оролцсон	5 оноо
		оролцоогүй	0 оноо
2.	Сургалт зохион байгуулсан	2 ба түүнээс дээш	5 оноо
		1 хийсэн хийгээгүй	3 оноо 0 оноо
3.	Салбар холбоо	10-аас дээш	5 оноо
		1-9	3 оноо
		салбар холбоо байхгүй	0 оноо
4.	Клуб /секц дугуйлан хамаарна/	10 -аас дээш	5 оноо
		1-9 бол	3 оноо
		клуб холбоо байхгүй	0 оноо
5.	хичээллэгчдийн тоо /олимпийн төрөл/	501- ээс дээш	5 оноо
		201-500 хүртэл	3 оноо
		200 хүртэл	1 оноо
6.	хичээллэгчдийн тоо /олимпийн бус төрөл/	301-ээс дээш	5 оноо
		101-300	3 оноо
		100-аас доош	1 оноо

**Тав.** Спортын холбооноос хүний нөөцийг бүрдүүлэх, сайжруулах талаар явуулсан үйл ажиллагааг дараах аргачлалын дагуу өгсөн үнэлгээний нийлбэрийн дунджаар дүгнэнэ.

д/д	Шалгуур үзүүлэлт	Тооцох аргачлал	Үнэлгээ
1.	Олон улсын шүүгчийн тоо	10-аас дээш	5 оноо
		5-9	3 оноо
		1-4	1 оноо
2.	Олон улсын шүүгчийн зэрэглэл ахиулсан	3 ба түүнээс дээш	5 оноо
		2	3 оноо
		1	1 оноо
3.	Улсын шүүгчийн тоо	20-аас дээш	5 оноо
		10-19 бол	3 оноо
		1-9 бол	1 оноо

**Нийт оноог дүгнэх аргачлал:** Нийт оноог гаргахдаа шалгуур үзүүлэлтүүдийн 5 бүрэлдэхүүн хэсгийн нийлбэрээр тооцон гаргаж, байр эзлүүлэн Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 53/45 тушаалыг үндэслэн зохих санхүүжилтийг хуваарилна. Санхүүжилтийг олгохдоо Эрүүл мэнд, спортын яам, тухайн спортын холбоодтой ажил гүйцэтгэх гэрээ байгуулж олгоно.